

Төрөлхийн гажиг, удамшлын эмгэгийн талаар
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Тэргүүн, гишүүд Монгол улсад тохиолдож байгаа “Төрөлхийн гаж хөгжил, удамшлын эмгэгийн талаар” Эрүүл мэндийн сайд Н.Удвалын итгэлийг ажлын журмаар хэлэлцээд ЗӨВЛӨМЖ БОЛГОХ нь:

Нэг.Монгол Улсын Их Хуралд:

1. Төрөлхийн гаж хөгжил, удамшлын эмгэгээс сэргийлэх, оношлогоо эмчилгээг олон улсын түвшинд хийх чиг үүрэг бүхий “Пренатологийн тусламж үйлчилгээний төв”-ийг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийг түшиглэн байгуулахад шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх.

Хоёр.Монгол Улсын Засгийн газарт:

1. Анагаах ухаан удамзүйн чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлж, удамшлын болон төрөлхийн гаж хөгжил, Монгол улсын бүх аймаг, нийслэлийн хүн амын дотор оюуны хөгжлийн хомсдлын өнөөгийн байдлыг тогтоох талаар үндэсний хэмжээнд судалж нэгдсэн мэдээллийн сантай болох асуудлыг шийдвэрлэх;

2. Хүн амаа угийн бичигжүүлэх, үүний тулд аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газрын дэргэд угийн бичгийн сургалт, сурагч багш нар бэлтгэх, өрөө танхим байгуулах асуудлыг Соёл, Спорт, Аялал жуулчлалын яамаар дамжуулан эрчимжүүлэх;

3. Зөвхөн төрөх үед оношлогдсон төрөлхийн гаж хөгжлийг бүртгэх бус, төрөх үедээ оношлогдоогүй хожуу оношлогдсон төрөлхийн гаж хөгжлийг бүртгэх, хянах тогтолцоог бүрдүүлэх.